



## ХААН БАНК ХК-ИЙН 2023 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

ХААН Банк нь 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс 19-ний өдрийн хооронд олон нийтэд 959 төгрөгийн нэгж үнэ бүхий 191,219,800 ширхэг энгийн хувьцааг санал болгох замаар нийт 183,379,788,200.00 (Нэг зуун наян гурван тэрбум гурван зуун далан есөн сая долоон зуун наян найман мянга хоёр зуун) төгрөгийг татан төвлөрүүлсэн болно.

Тус Банк нь энгийн хувьцааг нийтэд санал болгон арилжсанаар өөрийн хөрөнгөө нэмэгдүүлснээс гадна татан төвлөрүүлэх хөрөнгийн 16 хувийг банкны бүтээгдэхүүн үйлчилгээний цахим шилжилтийг хурдасгах мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтад, 19 хувийг цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, шинэчлэлтэд, 34 хувийг ногоон төсөл хөтөлбөрүүдэд болон 31 хувийг урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл, орон сууцны зээл санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

Мөн дунд хугацаанд харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, зайнаас хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа сайжруулахад чиглэсэн цахим шилжилтийн зорилтуудаа хэрэгжүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа хадгалах, тэлэх зорилтуудыг дэвшүүлсэн.

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

(төгрөгөөр)

Д/Д	Зарцуулалтын төрөл	Эзлэх хувь	ТТХ дүн	Зарцуулалт			Эх үүсвэрийн үлдэгдэл
				2023 оны 2-р улирал	2023 оны 3-р улирал	Нийт (2023.II + 2023.III)	
1	Мэдээллийн технологийн хөрөнгө оруулалт	16%	29.3 тэрбум	859.3 сая	2.1 тэрбум	2.9 тэрбум	26.4 тэрбум
2	Цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, сайжруулалт	19%	34.8 тэрбум	4.3 тэрбум	4.9 тэрбум	9.2 тэрбум	25.6 тэрбум
3	Ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт	34%	62.4 тэрбум	0	38.7 тэрбум	38.7 тэрбум	23.7 тэрбум
4	Урт хугацаат зээл /Орон сууц, хөрөнгө оруулалтын санхүүжилт/	31%	56.9 тэрбум	56.9 тэрбум	0	56.9 тэрбум	0
	Нийт	100%	183.4 тэрбум	62 тэрбум	45.7 тэрбум	107.8 тэрбум	75.7 тэрбум

- ХААН Банк нь 2023 оны 4 дүгээр сард Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлснээс хойш үйл ажиллагаагаа сайжруулахаар мэдээллийн технологийн чиглэлээр идэвхтэй хөрөнгө оруулсаар байгаа бөгөөд өнгөрсөн 6 сарын хугацаанд энэ чиглэлээр нийт 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулаад байна. Үүнд Үүлэн технологийн шинэчлэлтэд 519 сая төгрөг, Өгөгдлийн хадгалалт, технологийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор 1.6 тэрбум төгрөгийг зарцуулсан бол банк даяарх Дижитал шилжилтийн хүрээнд 825.7 сая төгрөгийг тус тус зарцуулаад байна. Мөн цаашдын мэдээлэл технологийн хөрөнгө оруулалтад Цахим аюулгүй байдал болон банкны дотоод процессын автоматжуулалтуудын төслүүд төлөвлөгдөөд байна.
- Тус Банк нь харилцагч, карт эзэмшигчдэдээ амар хялбар, хурдан шуурхай, нууцлалын өндөр түвшин бүхий орчин үеийн техник технологид суурилсан бэлэн бус төлбөр тооцооны үйлчилгээг хүргэдэг. Үүнийг тогтмол сайжруулан, харилцагчдынхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулан хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, сайжруулалтад татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 34.8 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 2023 оны 9 сарын 30-ны байдлаар 9.23 тэрбум төгрөг зарцуулсан байна.
- Ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтэд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 62.4 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн. Олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн хүрээнд ХААН Банк барилгын дулаан алдагдал, эрчим хүчний хэрэглээнээс үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулах зорилгоор тусгайлан зээлийн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлж, тэдгээр зээлүүдийг санхүүжүүлэхээр ажиллаж байна. Бид эрчим хүчний хэмнэлттэй барилгыг санхүүжүүлэх, гэр хороолол, зуслангийн бүсэд амьдарч буй иргэдийн амьдрах орчноо сайжруулахад чиглэсэн урт хугацаат, таатай нөхцөл бүхий ногоон зээлийн бүтээгдэхүүнийг гарган зах зээлд нэвтрүүлээд буй бөгөөд 38,665,838,215.00 төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- Иргэдийн орон сууцны зээл болон бизнесийн урт хугацаат хөрөнгө оруулалтын зээлийн олголтод татан төвлөрүүлсэн хөрөнгийн 56.9 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 2023 оны 2-р улиралд тус хөрөнгийг 100 хувь буюу бүрэн зарцуулсан байна.